


Гепатит С-ийн талаар мэдлэгтэй болох нь



MULTICULTURAL HIV
AND HEPATITIS SERVICE



Гепатит С-ийн талаар мэдэх нь яагаад чухал вэ?



Гепатит С-ийн эмчилгээ хийлгээгүйгээс элэг
ноцтой гэмтэж, элэгний хавдар үүсэхэд
хүргэдэг тул анхаарах нь чухал.

Гепатит С-ээр хэн ч халдварлах боломжтой.

Өнөөдөр бидний ярилцах сэдвүүд...





- ✓ Гепатит С-ийн талаарх ерөнхий мэдээлэл
- ✓ Гепатит С-ээр хэрхэн халдварладаг
- ✓ Гепатит С-ийн тархалтыг зогсоох
- ✓ Гепатит С-ийн шинжилгээнд хамрагдах
- ✓ Гепатит С-г эмчлэх
- ✓ Хэнд хэлэх хэрэгтэй, хэнд хэлэх шаардлагагүй болох
- ✓ Хаанаас дэлгэрэнгүй мэдээлэл авах




Гепатит С гэж юу вэ?

Гепатит гэдэг нь элэгний үрэвсэл юм.


- ✓ Гепатит С нь цусаар дамжин халдварлаж, элгийг өвчлүүлдэг вирус юм.
- ✓ Гепатит С эмчлэгддэг.
- ✓ Эмчилгээ хийлгэхгүй бол гепатит С нь элгийг өвчлүүлж, элэгний хавдар үүсэхэд хүргэдэг.




Гепатит С таны элгэнд хэрхэн нөлөөлдөг вэ?




Эрүүл элэг




Цочмог халдвар




Архаг халдвар





Элэгний гэмтэл
(Хатуурал)



Элэгний дутагдал



Хавдар



Гепатит С-ээр хэрхэн халдварладаг вэ?



Гепатит С-тэй хүний цус өөр хүний биед
орсноор халдварладаг.

Үүнд нүдэнд харагдахааргүй жижиг
хэмжээний цус ч хамаарна.

Гепатит С халдварлах замууд



- ✓ Гадаад улсад хийлгэсэн ариун бус эрүүл мэндийн, шүдний, гоо сайхны ажилбар, вакцин эсвэл мэс засал
- ✓ Шивээс, биеийн цоолбор зэрэг цустай харьцдаг ариун бус уламжлалт ажилбарууд
- ✓ Сахлын татуурга, шүдний сойз зэрэг цустай байх боломжтой бусдын хувийн эд зүйлсийг хэрэглэх
- ✓ Эх нь гепатит С-тэй бол жирэмслэлт эсвэл төрөлтийн явцад эхээс хүүхдэд
- ✓ Бэлгийн харилцаанд бэлгэвчгүй орох үед нэгний цус нөгөөгийн цустай хүрэлцсэнээр
- ✓ Санаандгүй байдлаар зүүнд хатгуулж гэмтэх
- ✓ Мансууруулах бодис эсвэл стеройдын тариурыг дамжуулан эсвэл дахин хэрэглэх
- ✓ 1990 оноос өмнө Австралид цус сэлбүүлсэн

Гепатит С дараах замаар халдварлахгүй...



Ариун цэврийн өрөө
дундаа хэрэглэх



Бусадтай хоол унд,
хоолны хэрэгслээ
дамжуулан хэрэглэх



Шумуул болон
бусад шавжид
хатгуулах



Усан сангаас



Найтаах



Ханиах



Тэврэлдэх



Үнсэлцэх

Гепатит С-ийн шинж тэмдгүүд юу вэ?

- ✓ Гепатит С-тэй олон хүнд өвчний ямар нэгэн шинж тэмдэг илэрдэггүй.
- ✓ Архаг гепатит С-тэй хүмүүс элэг нь их хэмжээгээр гэмтэх хүртлээ өөрийгөө өвдсөнөө мэдэхгүй байх боломжтой. Илрэх хүртэл олон жил болж болно.

Гепатит С-тэй эсэхээ мэдэх
цорын ганц арга зам нь цусны
шинжилгээнд хамрагдах юм.



Гепатит С-ийн шинжилгээ хийлгэх

Шинжилгээний төрлүүд

- ✓ **Эсрэг биетийн шинжилгээ:** өмнө нь гепатит С-ийн халдвар авч байсан эсэхийг шинжилдэг.
- ✓ **PCR шинжилгээ:** одоо гепатит С-ийн халдвар байгаа эсэхийг шинжилдэг.
- ✓ **Хатсан цусны толбо (DBS) шинжилгээ:** цусанд гепатит С байгаа эсэхийг шинжилнэ.



Гепатит С-ийн шинжилгээ хийлгүүлэх талаар эмчээсээ лавлаарай. Медикэйр карттай бол шинжилгээ үнэ төлбөргүй байдаг.

Шинжилгээ хаана хийлгэх вэ

- ✓ Өрхийн эмч (GP)
- ✓ Австралийн Гэр бүл Төлөвлөлтийн Үйлчилгээ
- ✓ NSW мужийн Бэлгийн Эрүүл мэндийн эмнэлэгүүд
- ✓ DBS шинжилгээг цахимаар



Гепатит С-ийн шинжилгээнд хэн хамрагдах хэрэгтэй вэ?

Хэрэв та Гепатит С-ийн халдвар ихтэй улсад төрсөн эсвэл амьдарч байсан бол гепатит С-ийн шинжилгээ хийлгэх хэрэгтэй.



Дараах тохиолдолд гепатит С-ийн шинжилгээ хийлгэх хэрэгтэй:

- ✓ Гадаад улсад цус сэлбэлт, вакцин, мэс засал эсвэл эрүүл мэндийн, шүдний эмчилгээ хийлгэсэн
- ✓ Зүслэг хийх, бумба тавих, гуаша зэрэг уламжлалт анагаах эмчилгээ хийлгэсэн
- ✓ Гепатит В эсвэл ХДХВ-тэй
- ✓ Хийлгэсэн шивээс эсвэл цоолборыг ариутгасан төхөөрөмжөөр хийсэн гэдэгт эргэлзэж байгаа
- ✓ Мансууруулах бодис, стеройд тарьж хэрэглэдэг, эсвэл тариураа бусадтай дамжуулан хэрэглэж байсан
- ✓ Хорих газарт хоригдож байсан
- ✓ Австралид 1990 оны 2 сараас өмнө цус сэлбүүлсэн.


Гепатит С-г хэрхэн эмчилдэг вэ?



Гепатит С-г Вирусийн эсрэг шууд үйлдэлтэй бэлдмэл (DAAs) нэртэй эмээр эмчилдэг.


Уг эм нь:

- ✓ Биеэс вирусийг устгадаг
- ✓ 8-12 долоо хоногийн турш хэрэглэх шаардлагатай
- ✓ Маш бага эсвэл ямар ч гаж нөлөөгүй
- ✓ Элэгний гэмтэл, элэгний хавдрын эрсдэлийг бууруулдаг
- ✓ Медикэйр карттай бол өртөг багатай
- ✓ Гепатит С-тэй хүмүүсийн 95%-ийг эмчилдэг



Гепатит С-ийн халдвараас өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?

- ✓ Шүдний сойз, сахлын татуурга зэрэг хувийн эд зүйлсээ бусдад дамжуулахгүй байх
- ✓ Шивээс болон арьсны цоолборыг ариун (цэвэр) багаж ашиглан зөвшөөрөлтэй, мэргэжлийн хүнээр хийлгэх
- ✓ Эрүүл мэндийн болон шүдний эмчилгээг зөвхөн зөвшөөрөлтэй, мэргэжлийн хүнээр хийлгэх
- ✓ Бэлгийн харилцаанд орохдоо бэлгэвч болон тосолгоо гель хэрэглэх
- ✓ Гадаад улсад аялах үед эрүүл мэндийн болон шүдний эмчилгээ хийлгэхдээ хянуур байх
- ✓ Цустай харьцахдаа бээлий өмсөх
- ✓ Тариурыг бусдад хэзээ ч дамжуулахгүй байх



Гепатит С-тэй холбоотой сөрөг хандлагын талаар ойлгох нь



Халдварт гепатиттай олон хүн дараах шалтгаанаар сөрөг шүүмжлэлд өртдөг:

- ✓ Хэрхэн гепатит С-ийн халдвар авсан талаарх бусдын таамаг төсөөлөл
- ✓ Гепатит С-тэй холбоотой зан үйлүүд

Эдгээрээс болж хүмүүс гепатит С-ийн халдварынхаа талаар ярихаас эмээдэг.

Сөрөг хандлагын улмаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл тулгардаг.

Хэнд хэлэх хэрэгтэй, хэнд хэлэх шаардлагагүй вэ?

Хуульд зааснаар дараах тохиолдолд заавал хэлэх шаардлагатай:

- ✓ Цусаа хандивлахдаа
- ✓ Эрхтэн эсвэл эр бэлгийн эс хандивлахдаа
- ✓ Эрүүл мэндийн даатгалын хүсэлт гаргахдаа
- ✓ Австралийн Батлан Хамгаалах Хүчинд ажилд орохдоо
- ✓ Австралид амьдрах визний хүсэлт гаргахдаа
- ✓ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн ажилтан

Та дараах хүмүүст хэлэх албагүй:

- ✓ Ажлын удирдлагууддаа
- ✓ Хамт ажилладаг эсвэл сурдаг хүмүүст
- ✓ Гэр бүлийн гишүүддээ

Эмч таныг гепатит С-тэй гэдгийг таны гэр бүлд хэлэх ёсгүй.



Гепатит С-тэй холбоотой тусламж хаанаас авах

General Practitioner - Өрхийн эмч (GP)

**Элэгний нарийн мэргэжлийн эмнэлэг,
мэргэжилтнүүд - 1800 803 990 www.hep.org.au**

**Бэлгийн эрүүл мэндийн
эмнэлэгүүд - 1800 451 624 www.health.nsw.gov.au/sexualhealth**

Медикэйр
шаардлагагүй

**Multicultural HIV and Hepatitis Service - ХДХВ болон
Гепатитын Олон соёлт Тусламж үйлчилгээ (MHAHS)
www.mhahs.org.au**

**Гепатит NSW - 1800 803 990
www.hep.org.au**

Эх хэл дээрээ тусламж авах

Та өөрийн эмч, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэй эх хэл дээрээ ярьж туслалцаа авах шаардлагатай бол:

- ✓ Орчуулга, Хэлмэрчийн Үйлчилгээ (TIS)-ний утас 13 14 50
- ✓ Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй бөгөөд таны нууцлалыг хадгална
- ✓ Үйлчилгээний ажилтанд хандаж хэлмэрчийн үнэ төлбөргүй үйлчилгээ захиалаарай



Өнөөдөр юу мэдэж авсан бэ?




Үнэн үү, Худал уу?


1. Гепатит С-тэй хүнтэй үнсэлцсэнээр гепатит С-гийн халдвар авч болно.
2. Бусадтай хоол хувааж идсэнээр гепатит С-гийн халдвар авдаг.
3. Вакцин хийлгэсэнээр гепатит С-гийн халдвар авахаас өөрийгөө хамгаалж болно.
4. Гадаад улсад хийлгэсэн шивээсийг ариутгасан төхөөрөмжөөр хийсэн гэдэгт эргэлзэж байгаа бол шинжилгээ хийлгэх шаардлагатай.

Гол санаа

- ✓ Гепатит С нь гепатит С вирусээр үүсгэгддэг элэгний халдвар
- ✓ Халдвартай цусаар дамжин цусаар халдварладаг
- ✓ Эмчилгээ хийлгэхгүй бол элгийг ноцтой гэмтээдэг
- ✓ Тус вирусийн халдвар авсан олон хүн үүнийгээ мэддэггүй
- ✓ Вакцин байхгүй хэдий ч эмчилгээ байгаа
- ✓ Гепатит С-гийн эмчилгээ 95%-ийн үр дүнтэй



Асуулт бий юу?



August 2025



Боловсруулсан:

NSW Multicultural HIV and Hepatitis Service (ХДХВ болон Гепатитын Олон соёлт Тусламж үйлчилгээ) (MHAHS) mhaahs.org.au



MULTICULTURAL HIV
AND HEPATITIS SERVICE

